



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/44

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны А/43 дугаар тушаалаар батлагдсан "Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газрын "Хөдөлмөрийн дотоор журам"-ын 5.2.5, 6.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймаг, орон нутгийн төр, захиргааны байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж 50 нас хүрсэн Нийтлэг үйлчилгээний албаны харуул Б.Гэлэгдорж, Төрийн дээд шагнал Алтан гадас одонгоор шагнагдсан Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн С.Ганчимэг нарт мөнгөн аяга, дурсгалын зүйл олгоход 320.000 (гурван зуун хорин мянга) төгрөг, шинэ жилийн арга хэмжээтэй холбогдуулан дурсгалын зүйл авахад 500.000 (таван зуун мянга) төгрөг тус тус зарцуулсугай.

2. Дээрх мөнгөн аяга, дурсгалын зүйлд зарцуулах нийт 820.000 (найман зуун хорин мянга) төгрөгийг нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (О.Цэрэнчимэд)-т зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ц.ГАНБОЛД

012100274